



14210 Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө 19, СБД 1-р хороо  
Утас: (976-11) 315679 Факс: (976-11) 311944  
Э-шуудан: [info@tdb-leasing.mn](mailto:info@tdb-leasing.mn), Вэб хуудас: [www.tdb-leasing.mn](http://www.tdb-leasing.mn)

## НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### Нийлүүлэгч байгууллагад тавигдах шаардлага:

- Нийлүүлэгч нь албан ёсны хаягт орших борлуулалтын цэгтэй байх;
- Нийлүүлэгч нь тухайн салбартаа сүүлийн 2 жилийн турш тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн байх;
- Нийлүүлэгч нь борлуулж буй бараанд баталгаат засвар үйлчилгээ үзүүлэх, сэлбэг хэрэгслээр хангах боломжтой байх;
- Түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн үйлчилгээг харилцагчиддаа сурталчлах, тайлбарлан таниулж, Түрээслүүлэгчээр үйлчлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, Түрээслэгчтэй хамтран ажиллах нөхцлийг зөвшөөрсөн байх;

### Түрээсийн зүйлд тавигдах шаардлага:

- Түрээсийн зүйл нь үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж болон хүнд даацын техник машин механизм, тоног төхөөрөмж байна;
- Түрээсийн зүйл нь шинэ, биет байдлын болон техникийн доголдолгүй, шууд ашиглах боломжтой, шаардлагатай дагалдах хэрэгслийн хамт байх;
- Түрээсийн зүйл нь эрхийн зөрчилгүй, шууд ашиглахад шаардагдах бичиг баримтуудын бүрдлийг бүрэн хангасан байх;

### Нийлүүлэгчээс бүрдүүлэх шаардлагатай материал:

- Хамтран ажиллах тухай албан хүсэлт;
- Анкет;
- Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм (нотариатаар баталгаажуулсан хуулбар);
- Үйлдвэрлэгчтэй байгуулсан дистрибьютерийн гэрээний хуулбар;
- Компанийн танилцуулга, бараа бүтээгдэхүүний танилцуулга;
- Нийлүүлж буй бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн үнийн санал;
- Сүүлийн 3-н жилийн санхүүгийн тайлан (дотоод болон татварын);
- Сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн задаргаа, үүнд: борлуулалт, зардал, бараа материалын үлдэгдэл, авлага, өглөг, өр төлбөр, урьдчилж орсон орлого ба урьдчилж гарсан зардал;
- Сүүлийн 12 сарын борлуулалтын тайлан (сар бүрээр);
- 3-5 жилийн бизнес төлөвлөгөө;
- Харилцагчид санал болгож буй нийлүүлэлт болон төлбөрийн ерөнхий нөхцөлүүд;
- Худалдах, худалдан авах гэрээний хуулбар (том дүнтэй);
- Бусад банк болон санхүүгийн байгууллага дахь сүүлийн 3-н жилийн дансны хуулга;
- Дотоод болон гадаад санхүүгийн байгууллагаас авсан зээл болон санхүүжилтын талаархи мэдээлэл, гэрээний хуулбар.

### Хамтран ажиллах нөхцөл

- Хамтран ажиллах гэрээгээр тохиролцох